

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2026 оны 02 дүгээр сарын 16-ний өдөр

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу шилэн дансны нэгдсэн цахим системд бүртгэлтэй мэдээлэл байршуулах, тайлан илгээх үүрэг бүхий Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж зэрэг нийт 19 байгууллага бүртгэлтэй байна. Үүнээс:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч 1,
2. Төрийн захиргааны төв байгууллага 1,
3. Төрийн захиргааны байгууллага 2,
4. Эрдэнэс Монгол нэгдлийн 7,
5. Төрийн өмчит үйлдвэрийн газар 2,
6. Төрийн өмчит компани 1,
7. Сайдын багцын урсгал зардлаас санхүүждэг ОУ-н төсөл 1,
8. Татан буугдсан 4 /Газрын тосны боловсруулах үйлдвэр төсөл, Геологийн судалгааны төв, Байгалийн хийн хоолойн Эрдэнэс газ төсөл (ЭМ харьяа), Газрын ховор элементийн суурь судалгааны төсөл (ЭМ харьяа)/ байна.

Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолоор “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ийг Эрчис ойл ХХК-д нэгтгэсэн боловч 2025 оны жилийн эцсийн байдлаар хуулийн этгээдийг татан буулгах шийдвэр Улсын бүртгэлийн ерөнхий газраас гараагүй байгаа тул тусад нь тайлагнав.

Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Эрдэнэс Монгол нэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 108 дугаар тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд дүрэмд эрх хэрэгжүүлэгч нь Засгийн газрын хэрэг эрхлэх газар байна гэж заасан.

Иймээс уг тогтоолын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт 8 байгууллагын 3 ангиллын 42 төрлийн мэдээллийг байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.

№	Яам, агентлаг, байгуул лагууд	Системд бүртгэлтэй байгуул лагын тоо	Мэдээллийн тоо	Мэдээл- сэн тоо	Хувь	Тай лан илгээх	Илгээ сэн	Хувь	Дундаж хувь
1	ТЕЗ- АҮЭБС	8	1,362	1,327	100	32	32	100	100
НИЙТ		8	1,362	1,327	100	32	32	100	100

2025 онд нийт 1,362 мэдээллийг байршуулахаас жилийн эцсийн байдлаар 1,260 мэдээллийг хугацаандаа байршуулж, 67 мэдээлэл хугацаа хоцорч байршуулж, 35 мэдээллийн байршуулах хугацаа болоогүй байна. Шилэн дансны цахим систем www.shilendans.gov.mn-д 32 удаа тайлан илгээж ажилласан байна.

№	Байгууллагын нэр	Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Хугацаандаа	Хоцорсон	Хугацаа болоогүй	Гүйцэтгэл
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /төсвийн ерөнхийлөн захирагч/	144	141	134	7	3	93.0%
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	171	166	156	10	5	93.9%
3	Ашигт малтмал, газрын тосны газар	183	178	169	9	5	94.9%
4	Үндэсний геологийн алба	171	166	153	13	5	92.1%
5	Геологийн судалгаа шинжилгээний төв	170	166	162	4	4	97.6%
6	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ	182	178	174	4	4	97.8%
7	Эрчис ойл ХХК	182	178	162	16	4	91.0%
8	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	159	154	150	4	5	97.4%
	НИЙТ	1,362	1,327	1,260	67	35	94.7%

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагууд нь тайлагнавал зохих мэдээллийг бүрэн байршуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 94.7 хувьтай байна.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ